



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/308

Улаанбаатар хот

Түр заавар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Коронавируст Халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг уламжлалт анагаах ухааны онолоор оношлох, эмчлэх түр зааврыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буянтогтох/, Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн зөвлөл /Д.Цэрэндагва/, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үеийн Монголын уламжлалт анагаах ухааны зөвлөх багт тус тус даалгасугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмжид дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газар /Д.Нарантуяа/-т үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилт, тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/185 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД




С.ЭНХБОЛД

21-Tushaal-A

141211508

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 дугаар
сарын 20 өдрийн А/227 дугаар тушаалын хавсралт



Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг
уламжлалт анагаах ухааны онолоор оношлох,
эмчлэх түр заавар

Үндэслэл

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэх, тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад уламжлалт анагаах ухааны идээ, явдал мөр, эм, заслын онолын дагуу оношлох, эмчлэх аргыг улс орнууд өргөн хэрэглэх багаа төдийгүй өвчнөөс сэргийлэх, дархлаа, биеийн тамирыг дэмжих, өвчний хүндрэлээс сэргийлэхэд үр дүнтэй байгааг судлан тогтоосон.

Энэхүү зааврыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн зөвлөл, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үеийн уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зөвлөх багаас Монгол Улсад КОВИД-19 халдварын үед уламжлалт анагаах ухааны аргаар эмчлэн эдгэрүүлж, урьдчилан сэргийлж байгаа судалгаа, туршлагад үндэслэн энэхүү зааврыг боловсруулав.

Зорилго

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын сэжигтэй болон магадлалтай, батлагдсан тохиолдолд уламжлалт анагаах ухааны идээ, унд, явдал мөр, эм, заслын аргаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил арга зүйгээр хангах

НЭГ. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үеийн уламжлалт анагаах ухааны аргаар эмчлэх, эрэмбэлэн ангилалт

1.1. Коронавируст халдварын батлагдсан тохиолдол гэж Эрүүл мэндийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/227 дугаар тушаалын дагуу бодит хугацааны Полимеразийн гинжин урвал /бх-ПГУ/-ын шинжилгээгээр эерэг, антигенд суурилсан түргэвчилсэн оношлуураар эерэг, магадлалтай тохиолдол эсхүл сэжигтэй тохиолдлын А эсхүл Б шалгуурт тохирсон, антигенд суурилсан түргэвчилсэн оношлуураар эерэг, батлагдсан болон магадлалтай тохиолдлын хавьтал болсон, шинж тэмдэггүй хүнийг коронавируст халдвар батлагдсан тохиолдол гэж үзэн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамруулна.

1.2. Иргэний хандсан хамгийн эхний эрүүл мэндийн байгууллага, тасаг /нэгж/ нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа халдварын тандалт, сэргийлэлтийн зааврын дагуу тархвар судлалын асуумж, эмнэлзүйн шинжүүдээр илрүүлэн таньж, тусгаарлана.

1.3. Уламжлалт анагаах ухааны эмийн эмчилгээг хөнгөн, дунд, хүндэвтэр, хүнд хэлбэрийн үед хэрэглэх ба лаборатори, дүрс оношилгоо болон судас, шээс, шинж тэмдгээр хяналт тавьж, өвчин даамжрах, биеийн байдал тогтворжихгүй үед төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн зөвлөх багаас зөвлөгөө авах, шилжүүлэх үйл ажиллагаа хугацаа алдалгүй зохион байгуулна.

1.4. Коронавируст халдварын дараа уламжлалт идээ ундаа, явдал мөр, эм, заслын эмчилгээг үргэлжлүүлэн хийж вирусийн халдварын урхагаас сэргийлнэ.

ХОЁР. Оношилгоо

2.1. Эмнэлзүйн илрэл

Тархвар зүйн судалгаагаар эмнэлзүйн нууц хугацаа 1-14 хоног, дунджаар 5-6 хоног, эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 1-3 хоногт, илэрч буй шинж тэмдгээс хамаарч 1-14 хоногт, дархлаа дарангуйлагдсан хүн >14 хоногт халдвар тараах эрсдэлтэй.

Ихэвчлэн халуурах, ханиалгах, ядрах, булчин өвдөх, хоолой өвдөх, хамар битүүрэх, толгой өвдөх, ядрах, мөн үнэрлэх, амтлах мэдрэхүй алдагдах зэрэг шинж тэмдгүүд илэрнэ. Цөөн тохиолдолд суулгах, бөөлжих шинжүүд илэрдэг.

Нийт тохиолдлын 5 хүртэл хувьд өвчний шинж тэмдэг 14 хоногийн дотор даамжран, хүнд хатгаа, амьсгалын цочмог дистресс хам шинж, олон эрхтэний дутагдалд хүргэж байна.

Уламжлалт анагаах ухааны онолоор коронавируст халдварын үед халдварт хижиг эс боловсорсон, халдварт хижиг дэлгэрсэн, уушгинд халуун буух, хоосорсон үеийн шинж тэмдгүүд илэрч байна.

2.1.1. Халдварт хижиг эс боловсорсон үеийн шинж: Удаан хугацаагаар жихүүцнэ. Толгой, хөл, гарын үесээр өвдөнө. Бие хүндэрнэ, залхуурна. Ямар нэг ажил үйл хийхийг үл хүснэ. Хар дарж элдэв зүүд зүүдлэнэ. Олон удаа эвшээнэ. Чих дүлийрнэ. Сэтгэл мунхуурна. Нарны илч, дулааныг хүснэ. Шинж тэмдэг нь харуй бүрий цагаар идэвхжинэ. Ам гашуу оргино. Толгой өвдөнө. Идээний дуршил хаагдана.

2.1.2. Халдварт хижиг дэлгэрсэн үеийн шинж: Бие хүндэрнэ. Хөлсний үнэр өмхий, нүдний өнгө нь улбар шар болно. Хэл, уруул, шүдэнд өнгөр тогтоно. Толгой өвдөнө, ам цангах нь их, сэтгэл дурдал сулрана.

2.1.3. Уушгинд халуун буух үед илрэх шинж: Цээжний өвчүү, ар хэсгээр өвдөнө, зүрх дэлсэнэ, ам, нүүр сэлхэрч хавагнана. Хоолой халуу оргино, хоолой сөөнө, олон удаа ханиана, шөнө унтах үед ханиалга ихсэнэ, толгой өвдөнө. Уушгины архаг болж хүндэрнэ, ханиах үед өгөр идээ, цустай цэр гарна.

2.1.4. Хоосорсон үеийн шинж: Сүүж, сүүжний толгой, бэлхүүс, яс, чөмөг нугууд нь ялгавартай өвдөнө. Бие хөлөрнө, нойр багатай болно. Толгой дүүрнэ. Чих шуугина. Хоосноор огиулна. Элдэв дэмий зүйл ярина. Үе үе чичрэнэ. Гадна халуун ихсэнэ.

2.2. Асуух шинжилгээ

2.2.1. Буусан орноор нь шинжлэх: шар үс, арьс, судас, мах, зургаан сав эрхтэн, таван цул эрхтэн, ясны аль оронд буусан эсэхийг шинжилнэ.

2.2.2. Халдварын үе шатыг тус бүр гурав хоногоор тооцож шинжлэх: Халуун, хүйтэн холилдсон бадган үе, шарын халуун дэлгэрсэн үе, цусны халуун дэлгэрсэн үе, таван цул эрхтэнд хий, цус хямралдах үе, уул, талын завсар хийн бэлгэ чанар идэвхжих үеийг шинжилнэ.

2.2.3. Өвчний суурь гэмээр нь шинжлэх: Хийн чичрэх, сэрвэлзэх, шарын халуун, цус дэлгэрэх, бадганы мунхрах, хэлгийрэх, хурмалын халдварын аль нь болохыг нарийн хянуур асууж тогтооно.

2.3. Үзэх шинжилгээ

2.3.1. Халдвар эс боловсорсон үеийн шинж: Шээс нь булингартай гарна. Хэлний өнгө нь цайвар, хэлний дээр хийн улаан бэржгэр гүвдрүүнүүд гарна.

2.3.2. Халдвар дэлгэрсэн үеийн шинж: Шээсний өнгө нь улаан, улбар шар, муухай үнэртэй, уур их, зузаан язмагтай байна.

2.3.3. Царцалтын завсарт хүрээд хоосорсон үеийн шинж: Шээсний өнгө нь улаан шар, өтгөн, булингартай. Хэлний өнгө нь улаан, ширүүн, хуурай.

2.4. Хүрэлцэх шинжилгээ

2.4.1. Эс боловсорсон үеийн шинж: Судас нь нарийн түргэн, нэг агшинд хөлбөрч лугшина.

2.4.2. Дэлгэрсэн үеийн шинж: Судас нь нарийн эрчимтэй, чанга, овойж хуйларч, хатуу, түргэн лугшина.

2.4.3. Хоосорсон үеийн шинж: Судасны лугшилт нь нарийн, хөлбөрөнхий, түргэн лугшина.

2.5. Лабораторийн шинжилгээ

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа коронавируст халдвартай өвчтөнг цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээ, D-dimer, CRP, ферритин, бусад шаардлагатай үзүүлэлтүүдээр хянана.

2.6. Дүрс оношилгоо

Амьсгалын цочмог халдварын хүндэвтэр, хүнд, нэн хүнд тохиолдлын үед уушгинд илрэх өөрчлөлтийн шинж чанар, эмгэгийн хүндийн зэргийг үнэлэх, өвчний тавиланг тодорхойлох зорилгоор шинжилгээнд хамруулна.

Эмнэлгийнхээ дүрс оношилгооны хүчин чадалд үндэслэн рентген зураг, компьютерт томографи болон цээжний хэт авиан оношилгооны аргаас сонгон оношилгоо, хяналт хийнэ.

Уушгины эмболи эсвэл хорт хавдар сэжиглэсэн тохиолдолд дүрс оношилгооны эмчтэй зөвлөн цээжний хөндийн тодосгогчтой КТ хийнэ.

2.7. Онош

2.7.1. ОУӨА-10 ангиллын дагуу коронавируст халдвар /КОВИД-19/-ын оношийн кодыг бичнэ.

ОУӨА-10 ангилалын дагуу шинэ коронавируст халдвар /КОВИД-19/-ын оношийг дараах байдлаар тэмдэглэнэ:

U07.1 Вирусологийн шинжилгээгээр батлагдсан тохиолдол

U07.2 Эмнэлзүй болон эпидемиологийн шалгуур үзүүлэлтээр шинэ коронавируст халдвар /КОВИД-19/ онош тавигдсан боловч лаборатори, вирусологийн шинжилгээ нь баталгаатай бус эсвэл хийгдэх боломжгүй тохиолдол

U08 Шинэ коронавируст халдвараар өвдсөн түүхтэй

U09 Ковидын дараах байдал /Post COVID-19 condition/

U09.9 Ковид-19 дараах байдал, тодорхой бус /Post COVID-19 condition, unspecified/

U10 Ковид-19 холбоотой олон эрхтэн тогтолцооны үрэвслийн хам шинж /Multisystem inflammatory syndrome associated with COVID-19/

U10.9 КОВИД-19 холбоотой олон эрхтэн тогтолцооны үрэвслийн хам шинж, тодорхой бус /Multisystem inflammatory syndrome associated with COVID-19, unspecified/

Z03.8 Коронавируст халдвар /КОВИД-19/ сэжиглэн ажиглалтанд буй тохиолдол

Z11.5 Коронавируст халдварыг /КОВИД-19/ илрүүлэх зорилгоор хийгдэж буй тандалт /скрининг/

Z22.8 Коронавируст халдвар тээгч

Z29.0 Хөл хорио

2.7.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын Уламжлалт анагаах ухааны өвчний онош

Эрүүл мэндийн сайдын сайдын 2020 оны 12 сарын 22-ны өдрийн А/619 тушаалын дагуу уламжлалтын онош тавина. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын халдварын үеийн уламжлалт анагаах ухааны онош тавих жишээ:

Жишээ 1.

Үндсэн онош: ТМ100- Нянгийн халдварт өвчин /КОВИД-19/
Үе шат: ТМГ00.03.02 Эс боловсорч, бадганаар сарних
Дагалдах өвчин: Бөөрний архаг

Жишээ 2.

Үндсэн онош: ТМ100- Нянгийн халдварт өвчин /КОВИД-19/ Хүнд хэлбэр
Үе шат: ТМГ01.01.01 Дэлгэрсэн халдварт халуун
Хүндрэл: ТМ100.03 Нянгийн халдварт цээжинд буусан уушгины богино хатгалга
Дагалдах өвчин: ТМК00.1 Зүрх долгисох

Жишээ 3.

Үндсэн өвчин: Z03.8 - Коронавируст Халдвар /КОВИД-19/ сэжиглэн
ажиглалтанд буй тохиолдол
Дагалдах өвчин: ТМЕ05 Их архаг барагдах

ГУРАВ. Эмнэлзүйн шинж болон ангилал

3.1. КОВИД -19 халдварын эмгэг жамын зураглал

КОВИД-19 халдвар нь эмгэг жамын дараах 4 үе шатыг дамжиж явагдана.

1. I үе шат нь бадганы цаг 3 хоног үргэлжилнэ. Өвчний хөнгөн хэлбэр эс боловсроогүй халууны шинж тэмдэг илэрнэ.
2. II үе шат нь шарын цаг 3 хоног үргэлжилнэ. Халуун өвчний орох үүдээр нэвтэрч дэлгэрсэн халууны шинж тэмдэг илэрнэ.
3. III үе шат нь цусны халууны цаг 3 хоног үргэлжилнэ. Цусны халуун цул эрхтэнд нөлөөлж тухайн цул эрхтний эмгэгийн шинж тэмдэг илэрнэ.
4. IV үе шат нь хий цус харшилдаж өвчин уул талын засврын халуун үе шатанд шилжинэ.

Халдварын эмнэлзүйн шинж нь хувь бодгалийн өвөрмөц чанар, халдварын эрчмээс хамаарч харилцан адилгүй байж болно. **Ялгавартай шинж нь:**

- Мөн чанараар өөрөө аяндаа боловсорсон эс боловсорсон халуун
- Өвчний мөн чанарын улмаас хийгээр боловсорч чадахгүй байгаа эс боловсорсон халуун
- Өвчний махбодын улмаас бадганаар боловсорч чадахгүй байгаа эс боловсорсон халуун
- Нөхцлийн эрхээр боловсорч чадахгүй байгаа эс боловсорсон халуун
- Боловсрох чөлөөгүй эс боловсорсон халуун.

Эс боловсорсон халууны эдгээр үе шатыг эмнэлзүйн шинж тэмдэг, асуух, үзэх, хүрэлцэх шинжилгээгээр эмч ялган дүйнэ.

3.1.1. Халдварт халууны эхэн үе буюу хөнгөн хэлбэр /Эс боловсорсон халууны үе/

Хий, шар, бадганы махбодын алинтай ч хавсарсан нь ялгаагүй өвчний хүч нь бүрэлдэж амжаагүй гэхдээ халуун нэмэгдэх нь тасраагүй, өвчний цус, тамирын цус хоёр

сүү, ус нийлсэн мэт бүхэл биед тархсан, халуун өвчний эхний үе шат юм. Халдварт халуун өвчний эхний 1 долоо хоногийн хооронд гардаг өвчний хүч нь бүрэлдэж чадаагүй мөртлөө нэмэгдэхийн сүүл нь тасраагүй байгаа халуун өвчний хурмал чанартай шид үе гэж үзнэ.

- удаан хугацаагаар бие зарайх, жихүүцэх даарах
- биеийн халуун тогтворгүй, оройн цагаар халуурах /38⁰с дээш/
- үдээс хойш харуй бүрийд халуурах
- толгой өвдөх
- шилбэний булчин үесийн голоор дагаж янгинаж өвдөх, бүх бие янгинах
- үнэрлэх амтлах мэдрэхүй буурах, мэдрэхгүй болох
- хоолой хөндүүрлэх, өвдөх, сэргэжнэх
- олон удаа эвшээх
- сэтгэл санаа хямрах, тогтворгүй болох, айж сандрах
- хар дарж, элдэв зүүд зүүдлэх
- ам гашуун оргиж, ам хатсан ч ус уухыг хүсэхгүй
- хоолны дуршил буурах
- хамар битүүрэх
- чих шуугих
- хэл нь цайвар өнгөртэй, хийн гүвдрүү гарах
- шээс нь уур үнэр бага боловч, улбар шар, өтгөн булингартай
- судас нарийн, түргэн хөлбөрөнхий.

3.1.2. Эс боловсорсон халууны боловсрох чөлөөгүй хэлбэрийн шинж тэмдэг:

- биеийн тамир тэнхээ муудах
- өнгө, зүс алдах, цог жавхаа, сүр сүлд буурах
- хоосон огиж, бөөлжих
- бие эвэршээх
- хэвтэж, суухын алинд ч өвдөлт намдахгүй өвдөх
- зовуурь шаналгаа ихсэх
- тамир тасрах
- хэвтэрт орох
- өндөр халуурах /40⁰с болон түүнээс дээш/
- халуун оргилоос давж аминд хүрнэ

3.1.3. Халдварт халууны II үе буюу хүндэвтэр хэлбэр /дэлгэрсэн халууны үе/

- ядарч сульдах
- толгой өвдөх
- их хөлрөх
- халуурна /38⁰с дээш/
- цэртэй ханиах, цээжээр өвдөх, олон ханиалгах
- нүд улайх, нүдний ухархайгаар өвдөх, нүд бүрэлзэх
- амьсгаадах, амьсгал бачуурах
- ам цангах
- ой тогтоолт муудах
- биеэс ялгарах хөл үнэртэй болох
- хэл, уруул, шүдэнд хаг тогтох
- ухаан балартах, ухаан алдах шинж илэрч болох

- шээсний өнгө улаан, муухай өнгөртэй, зузаан ерөм, язмагтай болох
- судас нарийн, эрчимтэй, түргэн лугших

3.1.4. Халдварт халууны III үе буюу уул талын завсар

- сүүжний толгой, бэлхүүс, яс, үес, шархирч өвдөх
- бие хөлрөх
- нойр багасах
- сэтгэл санаа хямрах, тогтворгүй болох, айж сандрах
- чих толгой дүүрч өвдөх
- чих шуугих
- хоосноор огиулах
- хий ханиалганх
- дэмийрэх
- үе үе чичрэх, халуурах
- хэлний өнгө улаан, хуурай ширүүн болох
- шээсний өнгө сүрлэн шар өнгөтэй, үнэртэй, хөөстэй
- судас хоосон, түргэн

3.1.5. Нянгийн халдварт халуун уушгинд буусан дэлгэрсэн халуун

- Ханиах
- Шөнө их ханиалгах
- Цэр улбар шар өнгөтэй, заримдаа цусны судалтай гарах
- Амьсгал давхцах
- Амьсгалж чадахгүй болох
- Цээжний ар, өврөөр хатгуулах, ханиахад цээжээр өвдөх
- Зүрх дэлсэх
- Толгой эргэх
- Дуу хаагдах
- Бачимдан сандрах
- Уруул хумс хөхрөх
- Нойргүйдөх
- Нүдний уураглаг бүрхүүлийн дээд талд судасны унжлага болон улаан хүрэн толбо үүсэх
- Хөлрөх
- Амьсгал тоо олширох
- Уушгины нойтон хэржигнүүртэй, амьсгал сул сонсогдох
- Нурууны 4,5-р үе эх хөвгүүн уушгины бэлчирт эмзэглэлтэй
- Судас нь түргэн, чанга, эрчимтэй, лугшина

3.2. Буусан орны ангилал, эмнэлзүйн шинж

Хүснэгт 1. Буусан орны ангилал, эмнэлзүйн шинж

Өвчний явц	Буусан орон	Эмнэлзүйн шинж
Хөнгөн	Шар үс	Хүч өчүүхэн, ямар нэг ажил үйл хийхдээ залхуурч бэрхшээнэ, бие ирвэгнэнэ, шар үс босно.
	Арьс	Жихүүцэнэ, толгой, үе мөч, хөлийн үесээр өвдөнө, нарны гэрэлд ээхийг хүснэ.
	Судас	Халуун төрж судас хямрана, сэтгэл будангуйрна, ам цангах нь их, ам гашуу оргино. Шээсний өнгө улаан, булингартай гарна.

	Мах	Толгой дүүрнэ, бие хүндрэнэ, мах халуу оргино, сэрүүнийг хүснэ.
Хүндэвтэр, хүнд, нэн хүнд	Сав эрхтэн	Хоолны дуршил хаагдана, үнэртэй суулгана, баас хатна, хэлэнд бадган салс, өнгөр тогтоно.
	Таван цул эрхтэн	Судас, шээсэнд халуун төрнө, хэл хатна, элдэв дэмий зүйл ярина, ам цангах нь их
	Яс	Хамар, ам, хэл хатна, шүдэнд өнгөр тогтоно, судас нь хоосон лугшина, чих дүлийрнэ, сэтгэл будангуйрна.

3.3. Өвчний суурийн ангилал, эмнэлзүйн шинж

Хүснэгт 2. Өвчний суурийн ангилал, эмнэлзүйн шинж

Өвчин явц	Гэм	Эмнэлзүйн шинж
Хөнгөн	Хий	Олон удаа эвшээлгэнэ, толгой эргэнэ, чих шуугина, биеийн шар үс босно, арьс ирвэгнэнэ, жихүүцэнэ, хөлс гарахгүй, хөл, гар, толгой чичирнэ, дэмий яриа ихсэнэ. Хоолны шингэлт муудна, нойр сэрвэлзэнэ, шанаа толгой эвэршээж хатгуулна.
	Шар	Сэрүүнийг хүснэ, толгой өвдөнө, ам гашуу оргино, халуурна, суулгана, баас, шээс, арьс, нүдний өнгө шарлана, машид хөлрөнө, хөлс нь муухай үнэртэй гарна, судас, шээсэнд халуун дэлгэрнэ.
	Бадган	Бадганы халдварт нь эхлээд буух газар нь дуршлын орон мөн бөгөөд ам нь заваарна, амт үнэр мэдрэхээ болино, шүлс, цэр нь элбэгшинэ. Бие алжаан хүндрэнэ.
	Хурмал	Хурмалын халдварт нь эхлээд тунгалагт буудаг. Тунгалаг нь бадган, шарын орон мөн тул бадганы хувь ихтэй байвал эс боловсорсон шинж тодордоггүй. Дараа нь эс шингэсэн буюу бор адил үзэгддэг ч гэсэн түүнийг эндүүрэлгүй байхыг чухалчлах хэрэгтэй.
	Шар ус	Судас нь нарийн, хоосон, дор түргэн лугшина, шээсний өнгө нь улаан шаргал, булингартай, нүүр хөөнө, өвчүү, хэвлий, ходоод, хянга, хөлийн шагай сэлхэрч хавагнана, хэл, шүд, буйл цайрна, бие хөлрөнө, амьсгаадна, ходоод цанхайна, идээ шингэхдээ бэрх болно, Арьсанд тархвал үс, шар үс зулгарна, загатнана, усан цэврүү гарна, мөн гал намс, нясуу гарна.
Хүндэвтэр	Хий	Удаан хугацаагаар чичрэнэ, гуя бэлхүүс өвдөнө, баас, шээс чавдагшина, толгой, бие, үе мөч бүгд нүдүүлсэн юм шиг болно, бүх ясаар өвдөнө.
	Шар	Аманд гүвдрүүнүүд гарна, цэр нь улаан гарна
	Бадган	Халуун нь аажмаар үүсэх хийгээд бөөлжинө, нойр ихтэй, хоол шингэхгүй, дуршил хаагдана,
	Хурмал	Сэтгэл мунхуурах бөгөөд дурдал буурна. Чих дүлийрнэ. Унтахдаа хар дарж, элдэв зүүд зүүдлэнэ. Цэрний өнгө нь улаан шар, цагаан наалдамхай гарна. Чөмөг, бэлхүүс, яс үесээр өвдөнө. Хоолой халуу оргиж сөөнө. Найтаана. Хамраас ус гоожино. Нүд улайна. Хавиргаар өвдөнө, ам их цангана. Халуун нь үе үе буурна. Өтгөн нэг үе хатаж, нэг үе суулгана. Шээс нь мөн ихсэж, багасна. Хөлс нь ч ихсэж, багасна. Нойр нь ихсэж, багасна. Нүд, шээс шарлах тул шарын өвчинтэй эндүүрэхгүй байхыг чухалчлах хэрэгтэй.

	Шар ус	Биеийн хүч өчүүхэн, үе үе хөлрөнө, ам, хэл хатна, өдөр, шөнө хоёуланд нь нойр ихтэй, олон удаа ханиана, нүдний зовхи, хөлийн шагай сэлхэрч хавагнана, бие хүндрэнэ, цээжээр хатгуулна, Булчинд дэлгэрвэл хэсэглэн өвдөнө, биеийн энд тэнд овойж товойж хавдана, улайгаад нимгэрч хагарвал идээ, цус, шар ус гарна. Ясанд шунавал булчин хатна, булчингийн өнгө хөхрөнө, хэсэглэн өвдөнө, нүүр хавдана. Хөл, гарын үеэр сэлхэрнэ, тахим нь атийна, шүд, хумс нь цайрч өнгөө алдана. Элгэнд буувал нүд шарлана, бие хүндрэнэ, дуршил хаагдана, хэл нь хөх, буйл нь цайрна, олон удаа найтаана. Бөөрөнд буувал ууц нуруугаар өвдөнө, доод бие хүндрэнэ. Саванд унавал дуршил хаагдана, суулгана, бөөлжинө, өтгөн хаагдана, хэвлий цанхайж өвдөнө.
--	--------	--

Хүснэгт 3. Өвчний суурийн ангилал, эмнэлзүйн шинж

Өвчин явц	Гэм	Эмнэлзүйн шинж
Хүнд	Хий	Өдөр шөнө нойр үгүй, судасны гүйдэл хөлбөрнө, таван цул бууснаар ам, хэл хатна, дэмийрэх нь их болно.
	Шар	Ам цангах нь их, цэр нь цустай гарна, цээжээр хатгуулна, хамраас цус гарна, халуун машид дэлгэрэх бөгөөд халууны шинж нь урьдаас нэмэгдэнэ, толгой хатгуулж өвдөх нь их, шанаа, дагзны судас чичирнэ, зулайгаар хүндрэнэ.
	Бадган	Баас, шээс, хэл, хумс, арьсны өнгө цагаан болно. Шээс дутуу гарна. Бөөр бэлхүүсээр өвдөнө. Чих дүлийрнэ.
	Хурмал	Биеэр улаан хар өнгөтэй жижиг гүвдрүүнүүд гарна. Бие чичирнэ, оюун санаа нь доройтоно, судас нь хоосон, түргэн лугшина, шээсний өнгө нь шар, булингартай болно. Толгой үе мөчний үесээр өвдөнө, дэмийрнэ.
	Шар ус	Шээс нь улаан өнгөтэй, энгэсэгний шүүс мэт өнгөтэй, судас нь нарийн түргэн, ёроолдоо гүйнэ, царайны өнгө шарлана, хөөнө, хэл, буйл, хумс цайрч өнгөө алдана, хөдөлгөөн хийхэд амьсгаадаж, уушиг, зүрх дэлсэнэ. Судсанд гүйвэл судас нь бүдүүрч, өнгө нь харлаж тодрон, судас нь булиглана, судасны дээр хавдана, үе мөч хүндэрч бадайрна. Уушгинд буувал амьсгал богино болно, хоолой сөөнө, өвчүү болон ар цээжээр хатгана, нүд, уруул, хөлийн шагай хавдана, амьсгал давхцана, ханиахад идээ, цус гарна.
Нэн хүнд	Хий	Хийн халдварт эцэстээ амин судсаар шургаж галзуурах шинж илрэнэ.
	Шар	Юм бодож байгаа юм шиг байдалтайгаар галзуурна, судас нь булхалзана, цусанд дэлгэрч шээс нь улаан гарна, цээж халуу оргино, эцэстээ ихэвчилэн ходоодоор замнаж гарах тул шингээгч шараар ходоодны галын илчийг гадагш гаргах бөгөөд хэл, ам уруул хатаж шүдэнд өнгөр тогтоно. Дуршил амаргүй болж хоосноор огиулна.
	Бадган	Юм бодож байгаа мэт бодлогоширон галзуурна, оюун ухаан мунхуурснаас элдэв дэмий зүйл ярих нь ихсэнэ, машид мартамхай болно, хүн танихаа болино, тархинд дэлгэрвээс хэлгийрнэ, орондоо өтгөн шингэнээ гаргана. Эцэстээ алдах газар нь бөөрөөр дамжиж гарах тул шээс хаагдана,
	Хурмал	Шээсний өнгө нь хар тос адил, хөөс өчүүхэн, даавуу юмуу хөвөн дүрвээс шарлана, нүд, хэлний дор, шанааны мах нугууд нь шарлана. Ам нь гашуу

		оргино, халуурна, нойр багасна. Дуршил хаагдана, хумс, шүд, буйл, хэл хагарна. Шүдэнд өнгөр тогтоно. Элэг, цесний дээр хуйларч өвдөнө. дарваас тэсэшгүй өвдөнө. Өвчтөнөөс өвчний муухай үнэр үнэртэнэ. Хүч, өнгө зүсээ алдана. Боловсрох чөлөөгүй бөгөөд 7 юмуу 9 хоновоос үхдэг тул боловсрохыг хүлээж болохгүй. Хэрэв боловсрохыг нь хүлээвээс судас нарийн, түргэн лугшина. Билгүүн хөнгөн, биеийн хүчээ алдана. Гадна халуун бага, арьсны өнгө алт адил шарлаваас цагаас хэтэрсэн бөгөөд өөрийн орон амин судсанд буусан тул түүнийг буцаах аргагүй тул үхдэг байна.
	Шар ус	Цул эрхтэнд идээ, ус хурж усан хаван үүснэ, ялгавартай дор машид хөлрөн, хамраас цус гарна. Зүрхэнд буувал сэтгэл будангуйрна, галзуурна, дурьдал доройтоно, хүйтэн сэрүүнийг хүснэ.

3.4. Үе шатны ангилал, эмнэлзүйн шинж

Хүснэгт 4. Үе шатны ангилал, эмнэлзүйн шинж

Өвчний явц	Үе шат	Эмнэлзүйн шинж тэмдэг
Хөнгөн	Халуун хүйтэн холилдож бадган, хий хавсарсан үе	Халуун толгойд бууж толгой өвдөнө, үе мөчний булчин, үеэр өвдөнө, жихүүцэнэ, олон удаа эвшээнэ. Ажил үйл хийх хүсэл төрөхгүй залхуурна. Хоол унданд дургүй болно, идсэн ч бөөлжиж гаргана. Наранд ээхийг хүснэ
	Шарын халуун дэлгэрсэн үед	Халуун нь мэдрэхүйн таван эрхтний үүдэнд бууснаар ам нь гашуу оргино, хэлэнд бадган сальс тогтоно, шүд урууланд өнгөр тогтоно, хамар хатна, чихний сонсгол муудна. Нүдэнд нуух ихтэй болж, нүдний хүүхэн хараа томроно. Шээс улаан өнгөтэй болно. Судас нь эрчимтэй лугшина.
Хүндэвтэр	Халдварт халуун цусанд буусан үе	Дан халууны бэлгэ чанар дэлгэрч судас, шээсэнд нь халууны шинж урьдаас ихсэнэ, хэл хатна, ам ихэд цангана, муухай үнэртэй хөлс гарна. Бие хүндрэнэ.
Хүнд, нэн хүнд	Таван цул эрхтэнд хий, цус хямралдах үе	Цусны халууны бэлгэ чанар ихэд арвидана, дэмий юм чалчина, дурьдал үл тодронго. Хэрэв өвчний хүч нь их байвал амин судсанд бууж, биеийн хүч өчүүхэн болно. Судас живэнхүй лугшина. Нүүр харлана, хэл хатаж ширүүн болно, галзуурна

ДӨРӨВ. Ялган оношилгоо

- 4.1. Дагшуур томуу
- 4.2. Гэмтсэн халуун
- 4.3. Хямарсан халуун
- 4.4. Хорын халууны язгуурын өвчнүүд

ТАВ. Эмчилгээ

5.1. Эс боловсорсон үеийн эмчилгээ

5.1.1 Эмийн эмчилгээ: Бадган хийн хувь ихтэй бол Мана-4 тан, Цус, шарын хувь ихтэй байвал Лэдэр-7, Брайвү-3, Норов-7 танг сайтар буцалган ширгээж бүлээнээр нь уулгана. Удаан хугацаа өнгөрсөн ч боловсрох нь удаан байвал Бигван -6, Бигван-8 талхан эмийг ясны шөлөөр даруулж уулгана. Сожэд, Дүдзи-10. Мөн Римжэд тан, Ханба тан, Прүлтан тангуудыг буцалгаж өгнө.

- **Нянгийн халуун эс боловсорсон, өөрөө боловсроогүй халуунд** өглөө Норов-7, Лидэр -7, Мана-4, өдөр Гавар-9 , Гавар-25 эмийн аль нэгийг сонгож, Зову-8 уулгана. Банздоо-12 нянгийн эсрэг эмийг хэрэглэнэ.

- **Нянгийн халдварт халуун эс боловсорсон, халуун боловсрох чөлөөгүй** бол Банздоо-12, Баатар-7, Чун-5, Чун-9, Лоцад гүнсэл эмийг хэрэглэнэ. Шарын цагт Гавар-3, Зандан-8, Гүргэм-7, Жугана-8 эмүүдээс сонгож хэрэглэнэ.

- **Нянгийн халдварт халуун эс боловсорсон, боловсрохгүй** бол Лидэр-7 эмээр боловсруулж, Зову-8, Гавар-9, Гавар-25, Банздоо-12 хэрэглэнэ.

5.1.2. Засал эмчилгээ: Ходоодонд бүлээн жин тавина. Дөрвөн толионд нь тос түрхэж илнэ.

5.1.3. Идээ, ундаа: Гурилын зутан, арвайн зутан, Өглөө, оройн цагаар буцалгасан халуун бүлээн ус, өдрийн цагаар буцалгаад хөргөсөн ус уулгана. Шимгүй, шингэхэд хялбар бүлээн, зөөлөн идээ хэрэглэнэ.

Хориглох идээ, ундаа: Тараг, айраг, хүйтэн ус, түүхий идээ, шингэхэд бэрх идээ нь бадган хийтэй нөхөрлөдөг тул хориглоно.

5.1.4. Явдал мөр: Дулаан хувцас өмсүүлнэ. Нар сүүдрийн завсар суулгана.

Хориглох явдал мөр: Хүнд хүчир ажил хийх, гал наранд халах, өдөр унтах, мах, архи тэргүүтэн илчлэг шимтэй идээ шарын халууныг үүсгэдэг тул тэвчинэ. Сүүдэрт даарах, чийгтэй газар суух, сэрүүн салхинд үлээгдэх, туулга, хануур, хөлс гаргах үйл, сэрүүн тан, талхан эмүүдийг хориглоно.

5.2. Дэлгэрсэн үеийн эмчилгээ

5.2.1. Эмийн эмчилгээ: Жабур-8, Лидэр-7, Брайвү-3, Мана-4, Норов-7, Дэгд -3, Гавар-9, Лидэр-5,7, Жажэг-5, Банзи-12, Зэмбэ-5, Дарву 5, Сэртүн-7, Лоцадгүнсэл, Марав-3, Сороол-4, 7, Мартан-11, Чун-5, Мүгвоюлжал, Чүсэргэмтан-9, Зандан-8, Гавар-25, Зову-8 эмүүдээс бодгалийн өвөрмөц чанар, өвчний мөн чанарт тохируулан хэрэглэнэ. Цустай цэр гарвал Сэру-25, цус зогсоох гүргэм-8, цэр ховхрохгүй бол Дарву-5, амьсгал давчдвал Гүнбрүм-11 эмийг хэрэглэнэ.

Цусны халууныг Тагтаггүнсэл, Гурван үрийн тан, Марчин-13, Суман-6, Цус шингэлэгч-4 тан, Марав-3, Чацаргана-5 эм, чацаргана, жүр-үр, бибилин, чихэр өвс, хужир зэрэг эмийн түүхий эдээр найруулсан эмийг хэрэглэж болно.

5.2.2. Засал эмчилгээ: Таван цул, зургааны сав эрхтний алинд дэлгэрсэн харгалзан Нодга, Рүтүн, Лонза, Жиншүг, Бралза, хурууны сэтрийн судас гэх мэт бэлчрүүдээс сонгож ханана. Халууны хүч дэлгэрч, хатгуулж буй газар хүйтэн жин тавина.

5.2.3. Идээ, ундаа: Цагаан будааны зутан, гурилын зутан, буцалгаад хөргөсөн ус уулгана.

Хориглох идээ, ундаа: Давс, мах, архи, сармис зэрэг халуун амт, чадалтай идээ, ундыг тэвчинэ.

5.2.4. Явдал мөр: Сэрүүн, сүүдэр, цэвэр агаартай байранд байлгана. Бие, хэл, сэтгэлээ амирлангуй, тайван байлгана.

Хориглох явдал мөр: Гал, наранд халах, хог новштой бохир байранд байх, өдөр унтах, хэт их явах, дасгал хөдөлгөөн их хийх зэрэг бие, хэлний хүнд хүчир үйлийг тэвчинэ.

5.3. Хоосорсон үеийн эмчилгээ

5.3.1. Эмийн эмчилгээ: Агар-15, Агар-35, Задь-5, Норов-7, Мана-4, Шингүн-8, Гүнбрүм-11, Сожид, Мана-4 зэрэг эмүүдээс бодгалийн өвөрмөц чанар, өвчний мөн чанарт тохируулан хэрэглэнэ.

5.3.2. Засал эмчилгээ: Үдэш нар шингэхэд үед 1,6,7-р бэлчирийг төөнүүрээр төөнөнө. Аль өвдөлттэй хэсгүүдэд гүнжидийн тос, үрийн тос, шар тос, тостой гурил, арвай хийгээд зэргээр бүлээн жин тавина.

5.3.3. Идээ ундаа: Бурам, иллэг түрхлэг, ясны тан гэх мэт хийг амарлиулах идээг өвчтний биеийн байдалтай уялдуулан аажмаар бүлээн хувийг ихэсгэж өгнө.

5.3.4. Явдал мөр: Өөрийн сэтгэлд зохистой ойр дотны хүнтэйгээ, дулаан орон байранд байх.

Хориглох явдал мөр: Даарах, салхинд цохиулах, яруу бус үгийг сонсох, хүнд хүчир ажил хийх, үймээн шуугиантай, олон хүнтэй газар байх, өндөрлөг газар байх

5.4. Бусад эмийн эмчилгээ

Жонлон-7, Диман-12, Олмосэ-25, Бойчун, Гарнаг-10, Лишь-6, Регончигтан, Цалгар-7, Шижид-6, Шинар-8, Арүр-10, Сэмбрүгүндэ, Сорозин-11, Гүргүм-7 зэрэг эм тангаас эмнэлзүйн шинж тэмдэг, хавсарсан гэм, өвчин буух орон, өвчний үе шат хам шинж, өвчтөний биеийн байдал, зэрэгт уялдуулан сонгож өгнө.

Хүүхэд (0-16) насанд Мана-4, Сороол-4, Данманайжог, идэр насанд Норов-7, Зову-8, Лүн агар-8, хөгшдөд Лидэр-7, Лоцадгүнсэл, Задь-5 зэрэг эмийг хэрэглэнэ.

Шинж тэмдэгтэй уялдуулан сонгох эм: Гавар-3,7,9,25, Зову-8,25, Жуган-25, Лоцадгүнсэл, Үзэм-7, Дарву-5, Банздо-12, Банжин-15, Зандан-8, Чун-5,9, Баатар-7, Тагтүггүнсэл, Агар-8,15,35, Мартан-11, Задь-5, Лиш-6, Сороол-4,7, Жамц-4, Брайвү-3, Уушгины зандан-8 зэрэг эмийг сонгож хэрэглэнэ.

Хавсарсан эмгэгтэй үйлчлүүлэгч: Сорозон-11, Нейровалин, Асваргал, Марчин-13, Шингүн-5,25, Гүргэм-7,13, Танчэн-25, Чинтан, Гиван-9, Бөөрний ар үр-10, Сүгмэл-10, Сожид-11, Сарийчун, Юна-4, Гагол-4,19, Сэрдог-5, Манагчимбо, Шижид-6, Руда-6, Данманайжог, Сэмбру-8, Бойгор-10, Нару-3, Бойчун-15, Жонлон-5, Сэндэн-4 зэрэг эмийг хэрэглэнэ.

5.5. Гүрэм засал

- Дээдийн номын уншлага, адис тид оршоосон рашаан хүртэх, тусгай найрлага бүхий дээдийн номын адис тидтэй утлагаар өөрийгөө болон орчин тойрноо ариусгаж утах.

- Маналын зүрхэн тарни, Цагаан шүхэртийн зүрхэн тарни, Дарь эхийн зүрхэн тарни, халдварт өвчнөөс сэргийлэх тусгай тарнийг тогтмол уншиж, өөрийгөө болон үр хүүхдээ адислах.

- Манал, Цагаан шүхэрт, Доржнамжом, Загджүсүм зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх ном засал уншуулах. Ёсчилон бүтээсэн сахиус зүүх зэрэг дээдийн номонд сүсэглэнэ.

5.6.Зүү эмчилгээ

I үе шатанд:

Зүү эмчилгээг уушги шимжүүлэх, бөөрийг дэмжих, биеийн эсэргүүцэл сайжруулах эмчилгээний зарчим баримталж хийнэ.

- LU7 /Lieque/, LU9 /Taiyuan/, BL13 /Feishu/, Du12 /Shenzhu/, Ren12 /Zhongwan/, Ren4 /Guanyuan/, KI3 /Taixi/, BL23 /Shenshu/ сүвүүдийг илрэх шинжийн дагуу сонгож авна.

- Боломжтой бол Ren4 /Guanyuan/, KI3 /Taixi/, BL23 /Shenshu/, Ren12 /Zhongwan/ сүвүүдийг төөнөнө /бүлээн жин тавина/.

II үе шатанд:

Зүү эмчилгээний үндсэн жор нь LI11 /Quchi/, TE5 /Waiguan/, LI4 /Hegu/, LU5 /Chize/ орно.

- Нэмэлтээр өндөр халуурч байвал GV14 /Dazhui/, их ханиалгахад LU6 /Kongzui/, цэр их бол ST40 /Fenglong/, амьсгаадахад BL12 /Fengmen/, BL13 /Feishu/, хоолойн өвдвөл LU10 /Yuji/, LU1 /Shaoshan/ сүвүүдийг хатгана.

- LU10, 11 сүвүүдийг гурвалжин зүүгээр хатгаж 2-3 дусал цус гаргаж болно. BL12 сүв дээр бумба тавина.

III үе шатанд:

Зөвхөн шинж тэмдгийн дагуу сүв сонгож хатгана. Халуурах, амьсгаадах гэх мэтчлэн. Эсвэл дээрх сүвүүдийг даран бариа хиж цочроож болно. Энэ үед зүүг нэмэх аргаар маш зөөлөн хатгахыг анхаарна.

Коронавируст халдвар авсан үйлчлүүлэгчдэд зүү эмчилгээ хийхэд халдвар хамгааллын арга хэмжээг чанд мөрдөж ажиллана.

ЗУРГАА. Коронавируст халдвар /КОВИД-19/ -ын ТОХИОЛДОЛ ХЯНАЛТ ЭМНЭЛГЭЭС ГАРГАХ

Хүснэгт 5. Эмнэлгээс гарах шалгуур

Шинжлэл	Эмнэлгээс гарах шалгуур
Асуух шинжилгээ	<ol style="list-style-type: none"> 1. Шинж тэмдэг илэрснээс хойш хамгийн багадаа 10 хоног болсон. 2. Хамгийн багадаа 3 хоног халуураагүй болон бусад эмнэлзүйн шинж тэмдэг сайжирсан.
Үзэх шинжилгээ	<p>Шээс шинжилгээ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шээс авсан даруйд халуун үеийн шинж <ul style="list-style-type: none"> - цайвар шаргал өнгөтэй, сарлагийн шинээр хайлсан тос адил, шингэн тунгалаг - бага зэрэг шивтэр үнэртэй - уур хэт их биш, хэт бага биш, удаан тогтох юмуу эсвэл түргэн арилахгүй тэгш - цэцэг буюу хөөсний их бага нь тэгш байна. 2. Үнэр замхрах үеийн шинж <ul style="list-style-type: none"> - язмагны нимгэн зузаан нь тэгш, өнгө нь хөх шаргал, шээсний дээр доор бүгдэд түгэж оршино - өрөм нь зуны хүчтэй салхинд үл гэмтэх усны өрөм мэт байна 3. Хөрсний дараах үе <ul style="list-style-type: none"> - савны захаар дотогш цагираглан буцна. - буцсны дараа өнгө нь цайвар шаргал, маш тунгалаг болно. <p>Бусад:</p> <ul style="list-style-type: none"> - Өвчтөний нүд, шүд, цэрэнд халууны шинж арилсан эсвэл сайжирч өөрчлөгдсөн байх

Хүрэлцэх шинжилгээ	Судасны лугшилт: эмчийн нэг амьсгалд /ямар нэг шалтгаанаар өөрчлөгдөөгүй/ 5 удаа лугших, 100-с дээш лугшилтанд судасны дээр, доор нарийн, бүдүүн лүгшилтгүй, доороо живэхгүй, дээрээ дэлгэрэхгүй, үе үе зогсохгүй, гүйдэл тэгш лугшиж байх
Лабораторийн шинжилгээ	Лабораторийн шинжилгээний үзүүлэлтүүд сайжирсан.
Дүрс оношилгоо /Шаардлагатай тохиолдолд компьютерт томографи, цээжний рентген зураг, уушигны хэт авиа/	Дүрс оношилгооны шинж тэмдэг сайжирсан.

ДОЛОО. Коронавируст халдвар /КОВИД-19/ эдгэсний дараах эмчилгээ, засал

7.1. Эмийн эмчилгээ

Халдварын дараа уламжлалт анагаахын эмийн заавраар доорх эмийн багцуудыг сонгож хэрэглэх нь бие махбодын үйл ажилагааг тэнцвэржүүлэх, өвчний урхаг үлдэхээс хамгаална.

Багц 1: Норов-7, Мана-4

Багц 2: Мана-4, Сожид, Норов-7

Багц 3: Мана-4, Сороол-4 *эсвэл* Сороол-7

Багц 4: Мана-4, Агар-8 *эсвэл* Агар-15

7.2. Засал эмчилгээ

Дөрвөн толь буюу хоёр гарын алга, хоёр хөлийн уланд шар тос, сүүлний тосоор сайтар иллэг хийнэ. Бусад шаардлагатай засал эмчилгээг эмчийн хяналт, зөвлөгөөний дагуу хийлгнэ.

7.3. Идээ, унд

Хонь, үхрийн махтай шөлтэй хоол, сонгино сармис, буцалгасан халуун бүлээн ус, зөгийн балтай ус, хийцтэй цай, сүүтэй цай, үзэм, чацарганы халуун бүлээн шүүс зэрэг илчлэг, шимтэй хоол, унд хэрэглэж биеийн хүч тамирыг тэтгэнэ. Өглөө заавал өлөө тайлах хэрэгтэй. Хоолны хэмжээ ихдүүлэх, эхнийх нь шингээгүй байхад дахин идэх, оройн хоолыг хэт оройтуулж хэрэглэж болохгүй.

7.4. Явдал мөр

- Хүйтний улиралд дулаан гутал, хувцас өмсөх, хувийн болон гадна, дотор орчны ариун цэврийг сайтар сахина, элдэв зүйлийн бохир хог шатааж бузар хиншүү хярвас гаргахгүй байх.
- Амьтны амь таслах, хулгай хийх, бэлгийн самуурал, архи уух зугаа цэнгэлд шунах, худлаа хэлэх, хэрэггүй чалчаа үг ярих, хоорондоо хэрэлдэж маргалдах зэрэг арван хар нүгэл үйлдэхгүй байх
- Сэтгэлдээ хүсэж тачаах, уурлаж унтууцах, өс хонзон, атаа хорсол үүсгэх, гомдож гутрах, зовж шаналах, айж эмээх зэргээр сэтгэлээ хямраалгүй, амар амгалантай байх.